



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2017 оны 6 сарын 29 өдөр

Дугаар А-190

Улаанбаатар хот

Журам, заавар батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх заалт, 36 дугаар зүйлийн 7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам”-ыг нэгдүгээр хавсралт, “Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг хоёрдугаар хавсралт, “Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг гуравдугаар хавсралт, “Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан шийдвэрлэх заавар”-ыг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тушаал, заавар гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А-80 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН